

МОННООС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04-р сарын 23 өдөр

Дугаар №01.18

Улаанбаатар хот

Хуралд оролцсон: Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

1. Д.Гиваапилын итгэмжлэлээр Д.Мөнхбат- 69732ш
2. Адам Холдворсын итгэмлэхээр Х.Эрдэнбаяр-69824ш
3. С.Алимаагийн итгэмжлэлээр С.Баяр-14443,
4. Марал импекс ХХК-ийн итгэмжлэлээр Х.Эрдэнэбаяр-69824ш
5. Шандас импекс ХХК-ийн итгэмжлэлээр Л.Нямжав-20556ш

Монноос ХК-ийн нийтэд гаргасан 350877ш хувьцаанаас 244379ш хувьцаа эзэмшигч буюу 69,6%-ийн саналын эрх бүхий оролцогч оролцсноор хурлыг хүчинтэй гэж үзээд хурлыг 17 цаг 05 минутад эхлүүлж, 1 цаг 30 минутад багтаан явуулахаар тогтоов.

Хурлын дэгийг ТУЗ-ийн нарийн бичиг М.Тунгалаг танилцуулж, хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Монноос ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайлан
2. Монноос ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт
3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох
4. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэх
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл
6. Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах, саналын дүнг гаргах, ХЭХ-д саналын дүнг танилцуулах

Хэлэлцсэн нь:

1. Монноос ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааг Х.Эрдэнэбаяр танилцуулав. 2017 онд үндсэн үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд ноосны агуулахууд, дулаан, цахилгаан, цэвэр бохир усны шугам бүхий үйлдвэрлэл, оффисын байр талбайнууд болон гаднах зам талбайг түрээслэх үйл ажиллагаа явуулсан.
2. Монноос ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг М.Тунгалаг танилцуулав.
3. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох
ТУЗ-ийн энгийн гишүүд: С.Мөнхжаргал- Кашмер Холдинг ХХК ГЗ
Адам Холдсворт- NPEAL ХХК ГЗ
С.Алимаа- Дизайн концепт ХХК ГЗ
Х.Эрдэнэбаяр- Монноос ГЗ
Ц.Цэнгэлбаяр- Ариг гал ХК Ерөнхий ня-бо
П.Оюунбаяр- Кашмер Холдинг ХХК менежер
ТУЗ-ийн хараат бус гишүүд: Л.Бүрэнтэгш-БЦД ХХК ГЗ
И.Сэр-Од- Монголын бизнесийн зөвлөлийн дэд захирал
Х.Оюунгэрэл- Бадрах өгөөж ХХК ГЗ нарыг тус тус томилов.
4. Компанийн удирдлагын зардлыг М.Тунгалаг танилцуулав. МОННООС ХК-ийн 2018 оны бизнес төлөвлөгөөгөөр борлуулалтын орлогыг түрээсийн орлогоор 2017 онд 113,8сая.₮ орсныг нийт орлого 129,2сая.₮-өөр төлөвлөсөн. Нийт зардлыг 125,4сая.₮ гэж төсөвлөж,

МОННООС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

татварын өмнөх ашиг 3,7 сая.₮, татварын дараах цэвэр ашиг 3,4 сая.₮ байхаар гишүүдийн 100%-ийн саналаар батлав.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл

Мөнхбат- 1. Аудитын дүгнэлтийг тайлан шиг бичсэн байна. Аудитыг дүгнэлт хэлбэрээр бичих ёстой. 2. Түрээсэлж журмын хашаа ажиллуулж байгаа компани нь журмын хашаа ажиллуулах эрхтэй юу? Замын цагдаагаас хяналт тавьж, асуудал үүсэх вий гэж анхаараарай. 3. Хувьцаат компани учраас ногдол ашиг олгосон уу? Хувьцаа нь нээлттэй борлогдож байгаа юу?

Эрдэнэбаяр- 1. Аудитын дүгнэлтийг анхаарч ажиллая. 2. Түрээслэгч компаниуд бүгд үйл ажиллагаагаа явуулах эрхтэй. 3. Компанийн цэвэр ашиг 5 сая.₮-өөс дээш болсон үед ногдол ашиг олгоно. 2017 онд 1,5 сая.₮ ашигтай ажилласан учраас ногдол ашиг олгоогүй.

С.Баяр- Аудитын газрыг Аудитын хорооноос сонгож аудит хийлгэх хэрэгтэй. Аудит дүгнэлтэнд өр авлагын талаар дүгнэлт байхгүй байна. Энэ өр авлагыг яаж барагдуулах гэж байгаа нь тодорхойгүй байна.

6. Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, саналын дүнг гаргаж Тооллогын комиссын дарга Б.Цолмон танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хаагдав.

Хурлын тэмдэглэл бичсэн: Монноос ХК-ийн ЕМ

Монноос ХК-ийн ГЗ



Д.Даваасүрэн

Х.Эрдэнэбаяр